



# Итгэгчийн андгай тангараг

Нэгдсэн  
Методист Чуулган

Mark W. Stamm

DISCIPLESHIP MINISTRIES  
Нэгдсэн Методист Чуулган

# ИТГЭГЧИЙН АНДГАЙ ТАНГАРАГ

*Нэгдсэн Методист Чуулган*

By Mark W. Stamm

*(Дагалдагч бэлтгэх ангид зориулан 2013 онд дахин хэвлэв)*

2017

Зохиолч : Mark W. Stamm

Эмхэтгэсэн : Lind R. Whited, David Whitworth

Орчуулсан : А. Чинбат (A. Chinbat)

Хянасан: Д. Цэнд-Аюуш (D. Tsend-Ayush) / Х. Наранчимэг  
(Kh. Naranchimeg) / Г. Цэвэлмаа (G. Tsevelmaa)

Эмхэтгэсэн : Нэгдсэн Методист Чуулган(UMC)

Хэвлэсэн газар : Монгол дахь Нэгдсэн Методист Чуулган

Хаяг : Чингэлтэй дүүрэг 11-р хороо Дэнжийн 1000-ын гудамж  
24 тоот байр.

[www.UMCdiscipleship.org](http://www.UMCdiscipleship.org)

Тусгай тайлбар гараагүй тохиолдолд библийн эшлэлийг The New Revised Standart Version ашигласан /2013 оны монгол библийн орчуулгыг ашиглав/. Англи хэл дээрх библийг ашиглах бүрэн эрхийг 1989 онд The National Council of the Churches of Christ Христэч боловсролын байгууллага эзэмшив. Тус номыг зөвшөөрөлгүй хувиран ашиглахыг хориглоно.

Нэгдсэн Методист Чуулганы “Итгэгчдийн андгай тангараг” номын бүрэн эрхийг 2002 онд “Discipleship Resources” эзэмшив. Тус номыг зөвшөөрөлгүй хэвлэх эсвэл цахимаар ашиглахыг хориглоно. Гэхдээ дипломын ажил болон дүгнэлтэнд ашиглаж болно. Зохиогчийн эрхтэй холбоотой зөвшөөрлийг Discipleship Resources, P.O Box 340003, Nashville, TN 37203-0003 холбогдон аваарай.

Анхны хэвлэл нь 2014 онд хэвлэгдсэн ба зохиогчийн эрхийг “Discipleship Resources” эзэмшинэ.

---

# ГАРЧИГ

---

<b>Оршил</b> .....	4
<b>Баптисмын ёслолд тулгуурласан андгай</b> .....	7
Бурханы бэлэг .....	7
Андгай нь хамт олны дотор хэрэгжинэ .....	10
<b>Чуулгануудын баримталдаг нийтлэг журмууд</b> .....	12
Гэм нүглийг орхиж бузар мууг эсэргүүцнэ .....	12
Христийг Аврагч, Эзэнээр хүлээн авч Түүний нигүүлсэлд түшиглэн, Христийг Эзэнээ хэмээн үйлчилнэ .....	16
Чуулган болон Библийн Үгэнд зориулалт гаргана .....	19
<b>Онцгой дуудлагадаа хариулах бидний андгай</b> .....	24
Нэгдсэн Методист Чуулганы итгэгч гишүүний дуудлага .....	24
Бие даасан чуулганы итгэгч гишүүний хувьд Христэд үйлчлэх дуудлага .....	29
<b>Хавсралт</b> .....	32
<b>Зохиогчийн талаар</b> .....	32

---

# ОРШИЛ

---

Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүний андгайн талаарх ярилцлагад оролцож байгаад баяртай байна. Та Есүс Христийн талаарх өөрийн итгэлээ ил тод, нээлттэйгээр илчлэн зөвшөөрч Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүн болох талаар бодож байж болох юм. Та өөр урсгал чиглэлийн чуулганаас Нэгдсэн Методист чуулганд шилжин ирж байж ч болох, эсвэл өнгөрсөн хугацааны туршид Нэгдсэн Методист чуулганы итгэгч байсан байж болно. Эдгээрийн аль нь ч байсан бай, чуулганы итгэгч гишүүний андгайг чин сэтгэлээсээ тунгаан үзэх нь нэн чухал. Яагаад гэвэл, энэ нь Христийн дагалдагч болохын хувьд хийх ёстой хамгийн энгийн зүйлсийн хураангуйг зааж байгаа юм.

Нэгдсэн Методист чуулганы дагалдагчийн гарын авлага (The Book of Discipline of the United Methodist Church)-аас үзвэл, чуулганы итгэгч гишүүн нь дараах зүйлсэд андгай өргөнө.

1. Бузар муу сүнсний нөлөөг эсэргүүцэн, энэ ертөнцийн бузар муугийн эрх мэдлийг үгүйсгэж, өөрийнхөө гэм нүглийг хүлээн зөвшөөрч гэмших.
2. Бузар муу болон шударга бусын дарамтыг эсэргүүцэн тэмцэхийн тулд Бурханаас өгөх эрх чөлөө, хүч чадлыг хүлээн авах.
3. Есүс Христийг өөрийн Аврагч Эзэнээр хүлээн авч, Түүний нигүүлсэлд тууштай итгэж найдан, Эзэн хэмээн Түүнд үйлчлэхээ амлах.
4. Христийн ариун чуулганы үнэнч нэг гишүүнээр амьдрахдаа энэ дэлхийд Христийн элчийн хувиар үйлчилнэ гэдгээ амлах.
5. Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд чин зүтгэлтэй байж, чуулганы ажил үүргийг хүчирхэгжүүлэхийн төлөө өөрийгөө зориулан дайчлах.
6. Залбирал, мөргөлд байнга оролцох, өргөл, үйлчлэл, гэрчлэлээрээ дамжуулан чуулганы үйл ажиллагаанд зүтгэлтэйгээр оролцох.

7. Хуучин Гэрээ болон Шинэ Гэрээнд бичигдсэн Христитгэлийн итгэл бишрэлийг хүлээн авч байгаагаа хүлээн зөвшөөрөх.



Бид дээрх нөхцөлүүдийг илүү тодруулан үзнэ.

Итгэгч гишүүний энэхүү андгай нь дагалдагч нарт хандсан Бурханы дуудлагыг илтгэдэг. Бурхан биднийг хаана ч байсан, юу ч хийсэн Түүний дуудлагыг хэрэгжүүлэхийг тушаадаг. Методист чуулганыг үндэслэгч Жон Веслигийн адилаар бид ч мөн “Дэлхий бол бидний номлолын индэр”<sup>1</sup> гэдэгт итгэдэг. Бид цугларалт, орон зайн хувьд хил хязгаараар хумигдалгүй, өөрсдийн үйл ажиллагааныхаа хүрээнд хязгаарыг тогтоодоггүй. Чуулган нь Бурханы сайнмэдээ болон гэрчлэлийн ажилд хамтарч, зөвхөн чуулганд ирж очихоор хязгаарлагдаж болохгүй. Бүх дэлхийд ил тод байгаа бидний энэ андгай нь дээрх утга учрыг багтаасан гэдгийг хүлээн авна. Түүнчлэн нөгөө талаар Христитгэлийн дагалдагчийн зарчим нь орон нутгийн бодит хөрсөнд суурилсан байх болно. Бид бүхэн өөрсдийн итгэлээ тодорхой онцлогтой нутгийн иргэд болон олон нийтийн дунд, бодит асуудал хийгээд онцлог шинжийг тээсэн хүмүүсийн дунд, өөрсдийн онцлог, сул талыг мэддэг хүмүүсийн дунд бодитоор хэрэгжүүлэх дуудлагыг авсан. Бурхан болоод бүх хүмүүсийг хайрлах хайр маань ойлголцдоггүй хөршөө мөн чуулганыхаа хүн нэг бүрийг хайрлахаас эхлэх болно. Энэхүү итгэгч гишүүний андгай нь бүх дэлхийн хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд дагалдагчийн зарчмыг хэрэгжүүлэхийг биднээс шаарддаг.

Бид хүмүүсээс андгайг шаардаж байгаа нь тэр хэмжээгээрээ чуулганы итгэгчдэд сахилга бат шаардлагатай гэсэн утгатайг

---

<sup>1</sup>“1738 оны 8 сарын 12 ноос 1739 оны 11 сарын 1 өдөр хүртлэх тэмдэглэл” John Wesley, in *The Works of John Wesley, Volume I* (Zondervan Publishing House, reproduced from an 1872 edition), page 201

ойлгох хэрэгтэй. Заримдаа та энэхүү дуудлагаа хаямаар санагдах уруу татлагад автах болно. Гэхдээ та ганцаараа энэ ачааг үүрээгүй гэдгийг санаарай. Бурханы ивээл дотор энэхүү андгайг өргөж байхдаа, Ариун Сүнс танд хүчийг өгч дуулгавартай дагахад тань туслана гэдэгт улам итгэлтэй болох болно. Хаана энэхүү андгайг сонссоноо бодоод үзээрэй. Би гарын авлагад бичээстэй андгайг иш татсан юм. Яагаад гэвэл, энэхүү андгай нь чуулганд хуулийн байр суурьтай эн тэнцэх учраас тэр билээ. Хэн нь чуулганы итгэгч гишүүн болох, мөн хэрхэн тэрхүү байр суурийг олж авсныг бид хэлж чаддаг байх нь хуулийн үүднээс үнэхээр чухал. Ямартай ч Нэгдсэн Методист чуулганы ихэнх гишүүд гарын авлагыг уншдаггүй. Оронд нь аяга таваг угаагчийн тайлбар ч юмуу эсвэл Жон Веслигийн номлол зэрэг илүү сонирхолтой зүйлсийг уншихыг илүүд үздэг нь нууц биш. Ерөнхийдөө бид баптисм, итгэлийн тосолгоо<sup>2</sup>, баптисмын амлалтаа дахин баталгаажуулах ёслол (reaffirmation of the baptismal covenant), гишүүнчлэлийн ёслол гүйцэтгэх баптисмын ёслол дээр итгэгч гишүүдийн андгайг сонсдог. Энэ нь итгэгч гишүүдийн андгайн талаарх уламжлал юм. Тэгвэл дээр дурьдсан баптисмтай холбоотой нөхцөл байдлын талаар болон үүний ач холбогдлын талаар харцгаая.

---

<sup>2</sup> Баптисм хүртсэн итгэгчийг илүү бат итгэлтэй байлган Ариун Сүнсний нигүүлслийг дүүрэн хүртээсэй хэмээгээд пастор духанд нь тос түрхдэг ёслол. Үүнийг ихэвчлэн католик шашин мөрдөн дагадаг.

---

# БАПТИСМЫН ЁСЛОЛД ТУЛГУУРЛАСАН АНДГАЙ

---

## *Бурханы бэлэг*

Нэгдсэн Методист чуулганы баптисмын ёслолд теологийн хийгээд сүнслэг утга учир тусгагдсан байдаг. Бурханы болон бие биенийхээ өмнө тунхагладаг бидний бүхий л гэрээ хэлбэрийн амлалтууд (covenant commitments) нь баптисмд тулгуурлана. Бид Бурханыг болон хөршөө хайрлаж байгаа нь эхлээд Бурхан биднийг хайрласан учраас юм (1Иохан 4:10-11). Бага насны хүүхэд баптисм хүртэхэд, тэдний асран халамжлагчид нь 7 амлалт буюу андгайнаас өргөн хүрээг хамарсан нэмэлт 3 андгайд хариулах (дахин хариулах) хэрэгтэй байдаг. Үүний дараа асран халамжлагчид болон бүх л итгэгч нар хамтдаа “Төлөөлөгчдийн итгэлийн тунхаг”-ийг уншсанаар Христэд хүнийхээ хувьд итгэлээ өчин тунхагладаг. Баптисмын ангид (font) залбирч байхад бүх итгэгчид түүхийн туршид оршоор ирсэн ЭЗЭН Бурханы авралын үйлсийг санан дурсдаг. Тэгээд тэрхүү авралын түүх нь чуулганы баптисмд, баптисмаар дамжуулан цаашдаа үргэлжлэхийг хүсэн гуйдаг. Дараа нь баптисмын ёслолыг үйлддэг. Бидний ёслолоор бол баптисм хүртэж байгаа хүүхдүүд баптисмын ёслолтой өдөр өргөх Ариун зоогт оролцдог. Мэдээж тэр хүүхдүүд өөрсдийнхөө амаар Есүс Христэд хандсан хувийн итгэл, амлалтаа өчих хүртэл тодорхой цаг хугацааг хүлээх хэрэгтэй боловч тухайн өдрийн Ариун Зоог-т бол оролцож болно гэсэн үг. Нэгдсэн Методист чуулганы итгэгчид бид өөрсдийнхөө хүүхдүүдийг Христийн бие ба цусаар дамжуулан хамтдаа нэгэн сэтгэлтэй (communitate) болно гэдэгт итгэдэг. Бичээсийн дагууд бол ингэж хамтдаа байснаараа хүүхдүүд чуулганы нэг хэсэг болдог (1Коринт 11:23-12:30). Бид ийм хүүхдүүдийг “Баптисм хүртсэн итгэгч гишүүн” гэж дууддаг. Мэдээж бид тэднийг одоохондоо “итгэлээ тунхагласан итгэгч гишүүн” гэж дуудахгүй. Итгэлээ тунхагласан итгэгч гишүүн нь чуулганы бүхий л үйл ажиллагаанд оролцож, үйлчилдэг итгэгчийг хэлнэ. Баптисм хүртсэн хүүхдүүд нь баптисм хүртсэн





гишүүнийхээ хувьд аль хэдийнээ ЭЗЭН Бурханы гэрээн доторх гэр бүлийн нэг гишүүн болно. Энэхүү байр суурь бол “үнэгүйгээр ивээсэн Бурханы бэлэг” юм.

Хэрвээ асран халамжлагчийн андгай сайн сахигдвал, энэхүү баптисмыг хүртсэн хүүхдүүд чуулганд сайн хамрагдаж чуулган дотор өсөж төлөвших болно. Чуулгандаа Библиэс суралцаж, залбирч, үйлчилж өсөн төлөвшинө. Бидний хүсч буй зүйл бол хүүхдүүд маань Библийг өөрсдийнхөө гэр бүлийнхний түүхэн замнал, мөн залбирал болон үйлчлэлийг амьдралынхаа хэлбэр болгон амьдрах явдал юм. Мөн тэд Ариун Зоогт оролцсоноор ЭЗЭН Бурханд талархах мөн Бурханаас ирэх бэлгийг нь хүлээн авахад суралцаасай гэдэгт оршино. Цаашлаад тэд мөргөлөөр дамжуулан олж авсан туршлагаараа Бурханлаг мэргэн ухаан ба зөвт байдлын мэдрэхүйгээ нээн хөгжүүлээсэй. Удалгүй тэд дахин баталгаажуулах ёслолын шатанд хүрээд, тэдний өмнөөс асран халамжлагчдын өчсөн андгайг өөрсдийн амаар өчин тунхаглах болно. Үүний хамтаар тухайн чуулганыхаа нэг гишүүн болохыг хүссэн андгайг ч мөн өчин тунхагладаг. Тэд итгэлийн тосолгооны ёслолд ч ийм андгайг өргөхдөө ч, эдгээр андгайг чухалчлан үзэж, сахин биелүүлэх хүч чадал нь Бурханы ивээл нигүүлсэлд тулгуурладаг болохыг санадаг.

Бидний бүхий л андгай нь баптисмаар дамжуулан өгөгдсөн нигүүлсэлд тулгуурладаг. Цаг хугацаа өнгөрч итгэлийн тосолгоог хүртсэн хоёр хүн гэрлэлтийн тангарагийг харилцан өргөхөөр Нэгдсэн Методист чуулганы тахилын ширээ рүү ирж

болох юм. Тэгвэл энэ өдрийн ёслол нь тэдэнд дараах зүйлийг сануулах болно. Тэд “Баптисм хүртэхдээ хүлээн зөвшөөрсний адилаар... Есүс Христийн нигүүлслээр нэг болж нэгддэг.” Мөн энэ хоёрын хэн нэг нь хожмын өдөр тослогдсон үйлчлэгчээр дуудагдвал, энэхүү дуудлагаа тодотгох ёстой. Тэгээд энэхүү дуудлагаа хүлээн авч хэрэгжүүлснээр их хурлын<sup>3</sup> тосолгооны ёслол дээр тосолгоог авах юм. Тэр өдөр тосолгоог авахын өмнө бишоп нь түүнд болон хуралд оролцож буй бүх итгэгч нарт “Чамд өгсөн баптисмыг санаж талархаарай” гэж хэлнэ. Үнэндээ баптисм бол бэлэг болгон өгөгддөг бүхий л үйлчлэлийн эхлэл юм. Эцэст нь гэрлэсэн хоёрын хэн нэг нь нас барсан тохиолдолд, тэдний гэр бүл, төрөл төрөгсөд, найз нөхөд мөн чуулганы хамт олны хувьд тэдний мөнхийн найдвар нь өөрсдийнх нь цогцлоон бий болгосон ололт амжилтад бус, харин баптисмаар дамжуулан үнэгүй ивээсэн Бурханы бэлэгт байгааг санан дурсах болно. Талийгаачийг газарт оршуулан Бурхан ЭЗЭНд түүнийг даатгахдаа бид ингэж хэлдэг: “Баптисмаар дамжуулан Христийг өөртөө өмссөний адилаар, одоо Христийн дотор алдрыг өмсөх болтугай.”

Баптисмын андгайн үгэнд тулгуурлан үйлдэх итгэгч гишүүний андгай нь Христитгэгчийн бүхий л зориулалт нь Бурханы нигүүлсэлд үндэслэснийг сануулдаг. Хүн төрөлхтөн бол үнэхээрийн учир дутагдалтай гэж бид үздэг – бидний харилцаа эвдэрсэн, өөртөө байгаа зүйлдээ талархахаас илүүтэй байхгүй зүйлдээ шунадаг, Бурханы бүтээл хийгээд Бурханы нэр алдрыг хүртэл өөрсдийнхөө өв мэт гамгүй хэрэглэдэг. Энэхүү асуудлуудаа шийдвэрлэхийн төлөө зүтгэдэг боловч ихэнхдээ бүтэлгүйтээд өнгөрдөг. Зарим тохиолдолд харин ч эсрэгээрээ асуудлуудыг улам дэвэргэж орхидог. Элч Паулын бичсэнчлэн “Би юу үйлдэж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй. Учир нь би хийх хүсэлтэй зүйлээ хийдэггүй, харин үзэн яддаг зүйлээ хийж байна.” (Ром 7:15, АБН 2013). Гэвч бид цөхрөл дотроо

---

<sup>3</sup> Энэ бол методист урсгалын бүх л чуулганы жилд нэг удаа зохион байгуулдаг их хурал юм. Энэ үед бүх л пастор болон тослогдсон ахлагч нар тухайн жилийнхээ тайланг тавихаар тус их хуралд оролцдог. Энэ үеэр шинээр пасторууд мөн тослогдсон ахлагч ч төрөн гардаг.

буугаад өгчихдөггүй. Жон Веслигийн адилаар бид түрүүлж ирсэн нигүүлсэл (prevenient grace)-д итгэдэг. Түрүүлж ирсэн нигүүлсэл гэдэг нь биднийг ямарваа нэгэн зүйлийг хийхээс өмнө өгөгдсөн нигүүлсэл болохынхоо хувьд бидний дагалдагчийн зарчмыг боломжтой болгодог. Ариун Сүнс биднийг төдийгүй бусад хүмүүсийг Бурхан уруу дагуулж, бидний сэтгэл зүрхэнд ариун хүсэл тэмүүллийг өгдөг гэдэгт бид итгэдэг. Ийм ивээлээс татгалзаж болох ч, хэрвээ бид амьдралд маань гарч ирсэн Бурханы ажилд нэгдэн оролцвол олон сайн зүйлс бий болох болно. Бид итгэгч гишүүний андгайг биелүүлж чадна (сахин биелүүлэх ч болно) гэж итгэдэг ч, Бурханы ивээл болон чуулганы чин сэтгэлийн залбирал бидэнд тусалдаг гэдгийг ухаардаг.

### *Андгай нь хамт олны дотор хэрэгжинэ*

Итгэгч гишүүний андгайг баптисм хүртээх ёслолын явцад өргөдөг учраас бид үүнийг хувь нэг хүний үйлдсэн энгийн зүйл гэж үзэхгүй. Бусад хүмүүстэй хамтаар үйлдсэн гэж үздэг. Нэгдсэн Методист чуулганы ойлгодог баптисм нь чуулганы цугларалт мөргөлийн явцад хийгддэг. Андгайг олны өмнө нээлттэй өргөдөг учраас бусад Христитгэгчид үүнийг ажиглан харж байдаг. Эдгээр хүмүүс нь шинэ итгэгч гишүүн өөрийнхөө өргөсөн андгайн үгэндээ хариуцлагатай байх, мөн сахин биелүүлэхэд нь туслах учиртай. Мөн бусад бүх гишүүд ч энэ мөчид өөрсдийнхөө андгайг дахин нэг санадаг.

Зарим нэг чуулганд гишүүнээр элсэх ёслолыг үйлдэхдээ бүх итгэгчдийг цуглуулахын оронд тусгал (semi – private) гэх аргыг ашиглах нь бий. Гэвч энэ бол буруу удирдамж юм. Баптисмд тулгуурлан үйлдэгддэг Христитгэгчийн андгай нь чуулганы бүхий л гишүүдийн өмнө нээлттэйгээр явагдах учиртай. Энэ нь бидний гэрчлэлээр дамжуулан Бурханы ажилд оролцож буйн наад захын илэрхийлэл юм. Олон нийтийн өмнө өргөж буй өчил нь хэцүү бөгөөд эрсдэлтэй байж болох ч чуулган нь бидэнд туслана гэдгээ амлан, олон олон гэрчлэгчид биднийг дэмжиж

байдаг (Еврей 12:1-2).

Баптисмын ёслол нь түүхэн үйл явц болдог төдийгүй даяар чуулгануудын хувьд бат үндэслэгдсэн. Энэхүү үнэн нь бидний андгай нь өнгөрсөн үеийн Христитгэгчидтэй холбогддог төдийгүй дэлхий даяарх бусад чуулгануудад үйлчилж буй ахан дүүстэй харилцан зохицол дор үйлдэгдсэн гэдгийг сануулдаг. Одоо бүгдээрээ Христитгэлийн нийтлэг өвийг тусгасан андгай тангаргийн талаар харцгаая.

---

# ЧУУЛГАНУУДЫН БАРИМТАЛДАГ НИЙТЛЭГ ЖУРМУУД

---

## *Гэм нүглийг орхиж бузар мууг эсэргүүцнэ*

Итгэгч гишүүний андгайн хамгийн эхний хоёр андгай нь гэм нүгэл ба бузар муугийн асуудлыг хөнддөг. Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүнээс дараах зүйлсийг үйлдэхийг шаардана:

Бузар муу сүнсний нөлөөг эсэргүүцэж, бузар муугийн хүчийг няцаан, өөрийнхөө гэм нүглийг хүлээн зөвшөөрч гэмшинэ.

Бузар муу хийгээд шударга бусын дарамт шахалтыг сөрөн Бурханаас өгсөн эрх чөлөө ба сүр хүчийг хүлээн авна.

“2 дугаар зууны дунд үе”- д бүрэлдэн тогтсон элчийн уламжлал (The Apostolic Tradition) хэмээгдэх анхны чуулганы дүрэм журмаар бол, хүмүүс (баптисмаар дамжуулан) чуулганы итгэгч гишүүн болохын тулд баптисм хүртэхийн өмнө сургагддаг байв. Гэхдээ энэхүү үйл явц нь маш хатуу гэмшлээс эхэлдэг байжээ. Ялангуяа зандалчид, шүтээн урлагчид, мөн завхайрагчид нэн даруй гэм нүглийн хэлбэрүүдээ хаядаг байлаа. Хэрвээ тэд ингэж хаяж чадахгүй байвал хойшлуулж, хаяж чадсан үедээ л дахин ирэхийг сануулдаг байна. Хэт удаан ч зайлшгүй арга байсан. 18-р зуунд Англи улсад ажиллаж амьдарч байсан Жон Весли ч гэсэн Методист чуулганы итгэгч гишүүн болохыг хүссэн хүмүүсээс мөн адил зүйлийг шаарддаг байжээ. Анхан үеийн Методист чуулганд итгэгч гишүүний андгай гэж байгаагүй ч, нөгөө талаараа “Ерөнхий дүрэм” (General Rules) – тэй байсан. “Ойртон ирж буй Бурханы уур хилэнгээс зайлан зугтаж, нүглээсээ аврагдах”-ыг хүссэн хүн бүр энэхүү ерөнхий дүрмийг дагах ёстой байв. Нэгдүгээр дүрэм нь, дэмжин туслагчид нь бусдад хохирол учруулалгүй байж, бүхий л хэлбэрийн бузар муугаас зайлан холдохыг шаарддаг байлаа. Цаашлаад Весли нь бузар муугийн нийтлэг хэлбэр – онцгойлон боол эзэмших, өндөр

хүүтэй зээл олгох, хатуу ширүүн харьцаа зэргээс зайлсхийх хэрэгтэйг тус дүрэмд оруулжээ. Түүний гаргасан жагсаалт нь гэм нүглийн бүх хэлбэрийг бүрэн оруулсан жагсаалт биш боловч, тэрхүү жагсаалтаар дамжуулан гэмшил нь агуулгын хувьд илүү тодорхой болох шаардлагатайг тайлбарласан байдаг.

Зарим хүмүүс энэ мэтийн гэм нүгэл ба бузар муугийн жагсаалтыг шүүмжилсэн, хуучинсаг зүйл гэж бодох нь бий. Гэсэн ч ихэнх нэгдмэл үзэл хандлага нь гэм нүгэл ба бузар мууг хаях явдал нь чуулганы хийдэг ажлуудын хамгийн үндсэн хэсэг мөн гэдэг. Анхан үеийн болон өнөө үеийн баптисмын ёслол нь үүнтэй төстэй андгайн үгийг багтаадаг ба эдгээрийн зарим нь бидний ашигладгаас ч илүү төвөгтэй. Жишээлбэл, Ромын Католик чуулганд итгэгч гишүүнээр элсэх насанд хүрэгчийн ёслол (Rite of Christian Initiation of Adults: RCIA) нь зовлонгийн 40 хоногийн гурав дахь, дөрөв дэх, тав дахь Эзэний өдөрт “муу сүнсийг зайлуулах”<sup>4</sup> ёслолыг (scrutinies) үйлддэг. Энэхүү ёслол үйлдэгдэж байх зуур нийт гишүүд нь шинээр баптисм хүртэгсдийг Христийн дотор чин үнэнч итгэлийн амьдралаар амьдрахад нь саад болох бүхий л муу зүйлээсээ чөлөөлөгдөхийн төлөө хамт залбирдаг. Муу сүнснээс аврах нь анхны чуулганд үйлддэг чөтгөр зайлуулах (exorcism) ёслолын залгамж юм. Зохистойгоор үйлдэх юм бол, муу сүнсийг зайлуулах ёслолын үед биед сонин хачин үзэгдэл гардаггүй. Мөн дээр нь гэм нүгэл, бузар мууг давж чуулганы залбирлаар дамжуулан эсэргүүцэн тэмцсэн гэдгийг чимээгүйхнээр хүлээн зөвшөөрч буйн илэрхийлэл болно.

Хоёр ч удаа дарааллан болсон дэлхийн дайн болон хэд хэдэн удаагийн харгислалаар толботсон 20-р зууныг эргэн харахдаа, энэ дэлхийд бузар муугийн хүч байхгүй хэмээн үзэх нь хэтэрхий гэнэн бодол болно. Сүүлийн үед болсон терроризм – 2001 оны 9 сарын 11-ний халдлага, 1995 оны Оклохама хотын дэлбэрэлт нь үүний тодорхой тайлбар болно. Одоо ч гэсэн

---

<sup>4</sup> Энэ ёслол нь муу сүнсэнд эзэмдүүлсэн хүнийг тухайн хорон муу хүчээс салгах ёслол. Энэ ёслолд тогтоогдсон хариуцагч тахилч нь гэмт чанар хийгээд харанхуйн хүчээс аврахын төлөө залбирч мөн муу сүнсэнд тушаан залбирч бас гар тавин залбирснаар муу сүнсийг хөөдөг.

тохиолдсоор байгаа хүүхдийн бэлгийн хүчирхийлэл ч мөн адил юм. Хамгийн цочирдмоор зүйл нь ихэнх тохиолдолд хүүхдийн бэлгийн хүчирхийлэл нь бидний сайн хүн гэж боддог байсан тийм хүмүүсээр үйлдэгдсэн байдаг. Энэ мэт гэм нүгэл ба бузар муу нь хүмүүсийг сүйрэл рүү хөтлөн, Бурханы бүтээсэн газар дэлхийг бохирдуулж, Бурханы захирч буй газар дэлхийг хүсэж мөрөөдөхөд хэцүү болгож байна. Ийм бодит байдлын төлөө Бурханы хүмүүс нь гэм нүгэл, бузар мууг илчлэн хаяж, улмаар эсэргүүцэн тэмцэхээр дуудагдсан.

Чуулган хэрхэн энэхүү эсэргүүцлийг гаргаж чадах вэ? Бидний хэв маяг энэ дэлхийд нэвчсэн хэв маягаас өөр үү? Ихэнх Америкчууд бузар мууг эсэргүүцэн тэмцэх гэдэг үгийг сонсохдоо, нацистын фашизмыг хөөн зайлуулахын тулд цусандаа хутгалдсан олон цэрэг эрсийг Ормандын эрэг рүү илгээж байсныг санаж болох юм. Мөн бид үймээн шуугиан болсон дэлхийн худалдааны төв (World Trade Center) – рүү гүйн орж аль болох олон хүнийг аврахын тулд өөрсдийгөө золиослосон Нью Йоркын цагдаагийнхан болон аврах ангийнхныг бодож болох юм. Эдгээр үйлдлүүд нь бүгд л бузар мууд “Үгүй!” гэж хэлж байгаа хэрэг. Эргэлзэх зүйлгүйгээр, тэдгээр үйлсэд оролцогчдын зарим нь өөрсдийнхөө хатуу хөтүү ажлыг Христийн дагалдагчийн зарчмын илэрхийлэл мэтээр үзэж байж ч болох юм. Тэдний үзэл бодол юу ч байлаа гэсэн, энэ мэтчилэнгийн золиосоор дамжуулан хүний амь аврагдаж байгаа бөгөөд энэ нь сайн үйлс мөн.

Бузар мууг эсэргүүцэн тэмцэхийн тулд цэрэг зэвсгийг ч ашиглаж байж болох юм. Яг ийм л шалтгаанаар, чуулган нь зүй зохистой цэрэг зэвсгийн хэрэглээний талаар үргэлжлүүлэн судалсаар байна. Тэгсээр ч ирсэн. Нэгдсэн Методист Чуулганы Нийгмийн Зарчим (United Methodist Social Principles) – д баталсны дагуу, “Бид дайныг хүсэхгүй бөгөөд, улс хоорондын зөрчлийг энх тайвны замаар шийдвэрлэхийг шаардана.” Цаашлаад цэрэг зэвсэг ашиглаж байгаа нь хяналтгүй булаан эзлэлт, дарангуйлал, үй олноор нь хөнөөхөөс илүү дээр гэж үзэх олон христитгэгчид цэрэг зэвсгийг ашиглаж ирснийг бид санах учиртай.

Хэрвээ зөвхөн хүчирхийлэл нь бузар мууг эсэргүүцэн тэмцэх цорын ганц арга зам гэвэл, бид сайнмэдээг зохих ёсоор нь ойлгоогүй байна гэсэн үг. Баптисм болон мөргөлийн явцад үйлдэгддэг итгэгчийн андгай нь бас нэг өөр замыг танилцуулдаг. Дээр дурдсан анхны чуулганы заншлаас харвал, баптисм хүртэж буй нэгэн нь баптисмын (baptismal font) ангиас итгэлийн хамт олон уруу шилжин орно. Ингэснээр зуучлан залбирал болон амар тайвны үнсэлт, Ариун Зоогт оролцоно.

Ийм хэвшсэн ёслол нь баптисм хийгээд мөргөлд гүн холбоо байгааг илэрхийлдэг. Зуучлан залбирал нь бузар мууг эсэргүүцэн тэмцэх нэгэн арга юм. Мөн амар тайвны үнсэлтээр дамжуулан амар тайвныг тунхаглах эвлэрлийн журам үйлчилдэг. Тэгээд энэ үед дайсагнал (enmity) нь гашуун үндэс хийгээд хүчирхийлэл болон батжихаас нь өмнө үндсээрээ устдаг. Цаашлаад Эзэний



ширээнд цуглаад өөрийгөө болон өөрийн авьяас чадвараа Бурханд өргөн, Есүс Христээр дамжуулан гүйцэлдүүлсэн Бурханы агуу ажлуудад талархан, энэхүү бүтээлийн ертөнцөд захирах чадварыг хэрхэн зөв ашиглахыг суралцдаг. Талх болон дарс нь үнэгүйгээр өгөгдөхөд, хувиа хичээх буулга нь эвдэрч, хамт олны талаарх шинэ үзэл хараа тодорхой болдог. Ариун Зоогийн шинэ харааг даган бид шинэ хүн болон гэрэлтсэнээрээ бузар мууг эсэргүүцэн тэмцдэг.

Энэ мэтчилэн мөргөлийн үйл нь биднийг цугладаг чуулгантай төдийгүй нэг хамт олонтой мөн энэ



дэлхий рүү гаран алхаж чадахуйц амьдралтай болгон гэрэлтүүлэх болно. Бурханы үгийг сонсогчийнхоо хувьд бид хайр дотор үнэнийг яригчид болдог. Ядуустай хамт байж тэдний төлөө ажиллахдаа, бид өөрсдөө гар хөлөөрөө зуучлан залбирлаар хашхиран залбирагчид болдог. Амар тайвныг дамжуулагч нь бүхий л хөршүүдтэйгээ амар тайван амьдрахыг эрмэлзэх болно. Ариун Зоогт оролцогчид нь Бурханы бүхий л бэлгүүдэд талархахыг сурах бөгөөд, мөн түүнийгээ олон хүмүүстэй хуваалцах болно. Үүнчлэн мөргөлд үндэслэсэн гэрчлэгчид нь эцсийн аргаа дайчлах хүртлээ эсэргүүцэн тэмцээр бузар мууг таслан зогсоох болно.

## ***Христийг Аврагч, Эзэнээр хүлээн авч Түүний нигүүлсэлд түшиглэн, Христийг Эзэнээ хэмээн үйлчилнэ***

Гэм нүгэл, бузар мууг эсэргүүцэн тэмцсэний дараа, гурав дахь андгай нь Есүс Христ рүү эрс тууштайгаар эргэх юм. Итгэгч нь дараахтай адилаар өчин тунхаглана. “Есүс Христийг Аврагч, Эзэн хэмээн амаараа тунхаглаж, Түүний нигүүлсэлд бүрэн найдаж, Түүнийг Эзэн хэмээн үйлчлэхээ амлаж байна.” Мэдээж гэм нүгэл юмуу ивээл нигүүлсэл рүү чиглэсэн хандлага маань давтамжгүйгээр нэг л удаагийнхаар дуусчихгүй. Харин үгээрээ өчих өчилд маань сайнмэдээний талаарх энгийн шаардлага ойлголтоос илүү утга учиртай байдаг. Энэ нь үнэнийг маш тодорхойгоор үг болоод үйлдлээр чангаар хашхирч буй хэрэг. Элч Паул үүний адил хөдөлгөөнтэй чанарыг ингэж хэлсэн.

“Харин энэ нь юу хэлдэг вэ? «Үг нь чамд тун ойрхон, аманд чинь, зүрхэнд чинь бий» гэдэг. Энэ нь бидний тунхаглаж буй итгэлийн үг юм. 9 Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно”  
(Ром 10:8-10).

Ийнхүү өчиж байгаа нь бид андгайн үгийнхээ дагуу амьдрах андгайн ард түмэн гэдгээ тунхаглаж буй хэрэг билээ. Ийм

хандлага нь эрсдэлтэй байж болох ба, учир нь Есүс Христийг “Эзэн” хэмээн дуудах нь өөрсдийгөө эзэн гэж үздэг хүмүүсийн байр суурийг ганхуулдаг. Зарим хүн “Өчигч” Максимус (Maximus “The Confessor” МЭ 580-662 он) – ын адилаар зовлонд ч унаж болох юм. Тэрээр Константинополийн хамба бөгөөд гаж буруу үзэлт Пирус (Pyrthus) – ийг эсэргүүцэн Есүс бол зуун хувь хүн, зуун хувь Бурхан хэмээн эцсээ хүртэл зүтгэснээрээ “Өчигч” гэх хочийг хүртсэн. Гэвч ингэж зүтгэснийхээ төлөөсөнд оногдох шийтгэлээр түүний хэл болон гарыг нь тасалсан билээ. Үүний адилаар, Адольф Гитлерийн нацист засгийг эсэргүүцсэн Германы цөөн Христитгэгчид “Өчигч” чуулган (Confessing Church) хэмээх хочийг авчээ.

Тэд аймшигтай аюул заналхийлэл дунд Христийг ил тодоор өчин тунхагласан. Тэдний дунд хамгийн их алдаршсан амиа өргөгч болох Дитрих Бунхойпор (Dietrich Bonhoeffer) – ийн амьдралаар дамжуулан бид, хэн нэгэн нь Христээс дуудлагыг авна гэдэг нь шууд ирээд үхээрэй гэсэн дуудлагатай адил болохыг ухаардаг.

Ихэнх тохиолдолд Есүс Христ рүү хандсан бидний өчил нь бидний амь нас, бие махбодид хохирол учруулаад байхгүй. Гэхдээ Есүс Христийг өчин тунхагласнаар бидний амьдрал хормын дотор орвонгоороо эргэчихгүй ч өөрчлөлт бол гарах л болно. Есүс, Өөрийг нь дагана гэдэг өөрсдийгөө үгүйсгэж загалмайгаа үүрэх явдал юм гэдгийг зааж өгсөн. Тиймээс Христийг өчин тунхаглана гэдэг нь тоолшгүй олон жижигхэн үхлийг илэрхийлж буй бөгөөд – бусдад үйлчлэхийн төлөөх бидний халуун хүслийг эс тооцсон ч – бид үйлчлэл дотор өөрөө өөрийгөө нээн олсоор явдаг. Нэгдсэн Методист чуулганд итгэгч гишүүний андгайг өргөхдөө, бид үүний адил үхэл ба амилалтын баптист хүч нөлөөн дотор өөрсдийнхөө амийг зориулан андгайгаа сахихаа амлаж буй хэрэг юм.

Гэхдээ бид өөрсдийнхөө хүчээр Христийг өчиж чадахгүй. Тиймээс бид Түүний ивээл нигүүлсэл, уучлал, эрх чөлөө болон оршихуй нь бидэнд хүчийг өгдөг гэдэгт итгэхээ амладаг. Нэгдсэн Методист чуулганы итгэгчийн хувьд Бурханы ивээл нигүүлсэлд

итгэж найдна гэдэг нь ямагт “нигүүлслийн арга хэлбэрүүд (the means of grace)”-ийн хичээл зүтгэлтэй холбоотой байна гэсэн үг. Энэхүү онцгой эрх бүхий арга хэлбэрүүдээр дамжуулан бид Бурхантай уулзаж мөн хэрэгтэй байгаа тусламжаа олж авдаг. Жон Веслигийн зааснаар, “Бурханы ивээл нигүүлслийг хүсэн тэмүүлэх бүх хүн Бурханы тогтоосон арга хэлбэрүүдээр дамжуулан соёрхох ивээл нигүүлслийг нь хүлээх юм. Хүмүүс арга хэлбэрүүдийг зүгээр л хадгалах биш харин ашиглах хэрэгтэй.”

Тэгвэл тэрхүү арга хэлбэрүүд нь юу вэ? Веслигийнхээр бол, Бурхан биднийг үг ба Ариун Зоогийг хуваалцахад, тэр чуулганы нөхөрлөл дотор бидэнтэй уулзана гэж амласан. Биднийг залбирахад мөн Библийг уншихад Бурхан бидэнтэй уулздаг. Мацаг барилт ч гэсэн ивээл



нигүүлслийн арга хэлбэр юм. Харин энэхүү ивээл нь автоматаар өгөгддөг юм биш ээ. Весли, Бурханы хараат бус байдал болон эрх мэдэлд итгэж байсан. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийнхөө сонголт ба хүслийн дагуу бидэнтэй харилцааг тогтоохдоо хараат бус. Мөн Весли, ивээл нигүүлслийн арга хэлбэрийн эцсийн зорилго нь хайр гэдгийг санаж байхыг хүссэн. Мөн биднийг ивээл нигүүлслийн арга хэлбэр рүү ойртон очихдоо энэ газар дэлхийд хандсан Бурханы зорилго хараанд өөрсдийн сэтгэлээ нээгээд ойртохыг ятгадаг. Дүгнэлт нь тодорхой. Бурханы ивээл нигүүлслийг хүртэхийг хүссэн хүн нь ийм ивээл нигүүлслийн арга хэлбэрүүдийг чадах чинээгээрээ ашиглах хэрэгтэй гэсэн үг юм. Хүмүүст ивээл нигүүлслийн арга хэлбэрүүдийг ашигла гэж хэлэх нь яг л сайхан хооллож, хангалттай дасгал хөдөлгөөн хийж, зохистойгоор амарч бай гэж хэлж байгаатай адил. Мэдээж хүмүүс үүн шиг сайн дадал зуршлуудаас авч болох олон үр

ашгийг хүсэх байх. Гэвч хүмүүс ийм дадал зуршлуудаас амархан хөндийрч хэт их ажиллаж, хэрэггүй, шим тэжээлгүй хоол хүнсэнд (junk food) түшиглэн амьдарч байна. Үүний адилаар Христитгэгчид ч заримдаа Үг болон ширээ (Word and Table) – гээр дамжуулан авдаг хүч чадлын нөөц баялагаа умартан, оронд нь библийн дагуу биш, мөн уламжлалаа дагаагүй сүнслэг буруу хоолыг хүсэмжилдэг. Заримдаа тэд дэндүү завгүй байдгаас өөрсдийнхөө төлөөх сүнслэг шим тэжээлийг огт авч чаддаггүй. Бурханы ивээл нигүүлсэлд итгэж найдна гэх андгайн үг нь тэнцвэртэй сүнслэг хоол тэжээлийг олж авна гэсэн утгатай.

## ***Чуулган болон Библийн Үгэнд зориулалт гаргана***

Мэдээж энэ бүхэн амлалтын ард түмний дотор явагдана. Христитгэгчийнхээ хувьд бид амлалтын гэр бүл болох чуулган ба гэр бүлийн түүхэн альбом болох Библийг хүлээн авсан хүмүүс. Бид энэ хоёртой хамт амьдрахаар шийдсэн хүмүүс. 4 дэх болон 7 дахь андгайн үг бол яг энэ амлалттай холбоотой зүйлийг дурддаг. Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүн нь дараах нөхцөл байдалд өөрийгөө зориулна:

Христийн ариун чуулганы итгэмжит нэг гишүүнээр амьдарч, улмаар энэ дэлхийд Христийн элчээр үйлчлэн амьдрахаа амлаж байна.

Хуучин Гэрээ болон Шинэ Гэрээнд агуулагдаж буй Христитгэлийн итгэлийг хүлээн авч, очин тунхаглана.

Энд өгүүлж байгаа дараалалд эдгээр хоёр зүйл залгаатай бус зайтай байгаа ч, баптисмын асуулгад гарч байгаа Бичээсийн дагуух итгэлийн тухай андгайн үг болох итгэмжит гишүүний тунхагт шууд дарааллан орсон байдаг. Эдгээр хоёр зүйлд тэр хэмжээний нягт холбоо бий.

Дээр дурдсаны адил чуулган бол бидний гэр бүл юм. Мөн бид

энэ гэр бүлээ хамтдаа хамгаалахаа андгайлах шаардлагатай. Бодит байдалтай нүүр тулбал – амьдрал төвөгтэй учраас хамгийн ойр дотны хүн маань ч гэсэн биднийг уурлахад хүргэдэг. Тиймээс бид ийм харилцаанаас татгалзах янз бүрийн шалтгааныг бодож үзэхэд хүрдэг. Яг энэ шалтгаанаас болж гэрлэлт ба гэр бүл нь андгайн үг дээр босгогддог:

...сайхан үед ч, хэцүү үед ч,  
баян үед ч, ядуурах үед ч,  
өвдсөн үед ч, эрүүл үед ч,  
үхэл л биднийг салгах хүртэл  
бид бие биенээ хайрлан, халамжилна...

Бусад бүх андгай тангарагын адилаар, гэрлэлтийн тангараг нь Бурханы ивээл нигүүлсэлд тулгуурладаг. Бид тэрхүү ивээл нигүүлслээр ам тангарагаа хадгалан үлдэж, тэрхүү ам тангараг дотор гэрлэгч хосууд үржин өсдөг гэдэгт итгэдэг. Бид чуулгандаа зориулалт гаргахын төлөө үүний нэгэн адил ам тангарагыг өргөх шаардлагатай. Энд бидний өгүүлж буй чуулган гэдэг нь бидний сайн мэддэг тэр л чуулган – бидний харж, хүрч, сонсож, үнэрлэдэг – түүнийг л хэлж байгаа юм. Олон тохиолдолд бид бусад хүмүүсээс ч илүүгээр тэрхүү чуулганыг харж, илүү ихээр мэдэрч байдаг.

Зарим хүмүүс чуулганыг хоёр нүүртэй харалган гэж буруутгаж болох юм. Мөн зарим нь чуулган бол хүмүүсийг шархлуулдаг, тэрхүү шарх нь асар том гэж чичилж ч болох юм. Аль аль нь үнэн. Чуулган нь гэм нүглийг үүрч байдаг. Гэсэн ч чуулган нь ивээл нигүүлслээр дүүрэн газар. Зарим хүмүүс уулын горхины дэргэд суух нь Эзэний өдрийн өглөө чуулганы танхимд суухаас хавьгүй илүүтэйгээр Бурхантай ойр байгаагаа мэдэрдэг гэж үзэж болох юм. Үүнтэй хэн маргах билээ? Би хувьдаа “Уулын горхины хөвөө” – ний оронд “Бейсболын талбай” гэх үгийг хэрэглэхийг хүсэж байгаа ч, тэглээ ч гэсэн энэ илэрхийлэлд бас л ямар нэг хувийн хүсэл сэтгэл үлдсэн байна. Зарим шашинлаг бөгөөд сүнслэг илэрхийлэл нь зөвхөн өөрийгөө болон өөрийнхөө хүсэл бодлыг л дахин дахин бодохыг шаарддаг. Харин Христитгэлийн итгэл нь дээрх шиг хувийн шинжтэй биш.

Библиер дамжуулан уншсанчлан бидний Бурхан бол, төгс бус урам хугарам гэр бүл, тэгээд бас дутагдалтай байдалтай ч хамт ажилладаг. Бурхан мөн дагалдагчид болон чуулганууд бас арван хоёр дагалдагч, 70 дагалдагч, 120 дагалдагч бүгдтэй нь хамтран ажилладаг (Лук 9:1-6, 10:1-12, Үйлс 1:15-26). Бурхан бол Цор Ганц – үнэхээр тийм! – гэхдээ Ариун Эцэг, Ариун Хүү, Ариун Сүнсний Гурвал ч гэгддэг. Тиймээс Христигтгэлд Бурхан Өөрөө ч гэсэн тодорхой утгаараа Нэгэн хамтрал юм. Энэ утгаараа хэрвээ та хамт олны дотор ажилладаггүй Бурханыг хүсч байгаа бол, бидэнд өгөгдсөн түүхээс арай ондоог эрж хайх хэрэгтэй. Бидний Хуучин Гэрээ болон Шинэ Гэрээнээс уншдаг Бурхан бол Өөрийнх нь амлалтын ард түмнийг байгаа чигээр нь хүлээн авч, мөн тэдний төлөө зориулалт гаргахыг танаас хүсдэг юм.

Тэгвэл ингэж зориулалт гаргасны үр ашиг нь юу байх вэ? Хамгийн чухал үр ашиг нь амьд оршигч Христийн оршихуй юм. Эзэн үнэнээр амлан айлдахдаа итгэгч бидний дунд хамт байна гэсэн – “Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав.” (Матай 18:20). Өнгөрсөн хугацааны турш чуулганд Библийн үг уншигдаж, тунхаглагдахад бидний сэтгэл зүрхэнд халуу шатаж (Лук 24:32), талх хуваалцахад үхлээс амилсан Христийг таньж мэднэ гэж үзсээр ирсэн. Үнэхээр үхлээс амилсан Христийн гайхамшиг нь миний эгч дүүс, ахан дүүсийн дунд бодитоор оршдог. Тэд миний итгэлийн өчлийг сонсоод Бурханы уучлалыг тунхагладаг. Тэд намайг тэврээд, надтай хамтдаа инээж бас уйлж, энэ бүхнээр дамжуулан Бурхан намайг эдгээдэг. Эгч, ахан дүүс маань миний сул талыг мэддэг болохоор би тэдний өмнө шударга байж чаддаг. Мөн түүнчлэн, тэд миний нөөц чадавхийг ч бас мэддэг учраас миний авьяас чадварыг урамшуулдаг. Тэд өөрсдийнхөө өв хөрөнгө хийгээд мэргэн ухаанаа надтай хуваалцаж, бас надад зааж сургах хүнийг танилцуулж өгдөг. Намайг гэсэн тэдний зориулалт зүтгэл надад хэрэгтэй байдаг шиг, тэдэнд ч гэсэн тэднийг гэсэн миний зүтгэл зориулалт хэрэгтэй.

Чуулгандаа хамтдаа үйлчилдэг бидний амьдрал нь үргэлжид Хуучин Гэрээ ба Шинэ Гэрээг судлахаар биднийг хөтөлдөг. Чуулган маань ямар ч төрхтэй байсан тэр л байгаагаараа миний

гэр бүл адил, Библи ч гэсэн бидэнд тэр л байгаагаараа өгөгдсөн юм. Дахин нэг хэлэхэд, бид Библийг гэр бүлийн хэзээ ч үл устах альбом гэж бодож болно. Хулгайчид болон завхайрагчдын тухай түүх арилгагдаагүй. Хааяа дүрсгүйтдэг байсан нэгэн нь Давид хаан шиг баатар ч болох нь бий. Библи нь бидний үндэс суурь болох түүхүүдээр биднийг хангадаг. Тиймээс хэрвээ бид Библиэ мэдэхгүй, түүнийг үргэлжид тунгаан бясалгахгүй бол чуулган ба тэр чуулганы нэг гишүүн болох бидний яриа ч ойлгогдохгүй байж болохыг санах хэрэгтэй. Гэсэн хэдий ч Библийн бүхий л түүхүүд нь бидэнд амлалтын ард түмний тухай ойлгоход тусладаг ч, тэрхүү түүхүүд нь бүгдээрээ бидний бүхэл чанарт тулгуур үүргийг гүйцэтгэдэггүй.

Баптисмын ёслол дахь Элч нарын тунхаг нь чухал бүрдэл зарчмын үүргийг гүйцэтгэдэг. Бид баптисм болон багжуулах ёслолыг хүртэгчдэд “Хуучин Гэрээ ба Шинэ Гэрээнд агуулагдах Христитгэгчийн итгэлийг тунхагласнаар хамт олонтойгоо нэгдэхийг” урих үед, бид Элч нарын тунхагаар хариулдаг. Ингэснээр бид эртний хэв маягт үндэслэсэн мөргөлийн урьдын хэв маягийг дагадаг.

Библийн талаарх асуултад хариулахын тулд Элч нарын тунхгийг ашиглах нь ухаалаг тактик юм. Яагаад гэвэл, ингэснээрээ Библи бол голдуу үйлдэлтэй холбоотой дүрэм журам юмуу Бурханы тухай зарчим, эсвэл биелүүлэх ёстой амлалтуудын жагсаалт, бүр цаашилбал өө сэв, дутагдалтай хувь хүн, гэр бүлүүдийн тухай хачин бас эмгэнэлтэй түүхүүдийн цуглуулга биш юм гэдгийг сануулж өгдөг. Элч нарын тунхаг нь чуулганд Библийн хамгийн чухалчилж үздэг хэсэг нь юу болохыг ойлгоход тусладаг. Библи нь Ариун Гурвал – Ариун Эцэг, Ариун Хүү, Ариун Сүнс – ээр илчлэгдсэн Бурхан ЭЗЭНийг гэрчилдэг. Бурхан ЭЗЭН бол бүхнийг Бүтээгч. Библийн цөм нь Есүс Христийн амьдрал ба үхэл мөн амилалт юм. Бид Есүс Христээр дамжуулан амийг олж, Түүний ажил үйлчлэл нь Ариун Сүнсний хүчээр чуулганд үргэлжилсээр байгаа. Энэ бол Библийн гол агуулга юм.

Элч нарын тунхагт бүхий л асуултын хариулт байдаггүй. Энэ нь бидэнд улс дамнасан терроризмын асуудлыг хэрхэн

эсэргүүцэх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог хэрхэн байгуулах, мөн боловсролын шинэчлэлийг хэрхэн хийх тухайд тодорхой хэлж өгдөггүй. Үр хөндөлт, ижил хүйстэний талаар ч тодорхой өгүүлдэггүй. Баптисм хүртэхэд тохиромжтой нас юмуу, баптисмын ёслолын хэв маягийн талаар ч дурддаггүй. Христийг дахин ирнэ гэдгийг хэлдэг ч хэзээ хэрхэн ирэхийг нь хэлдэггүй. Бид ийм асуудлууд хийгээд эдгээртэй төстэй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Библиэ дэлгээд, өөрсдийнхөө сэтгэлийг нээгээд ярилцах учиртай. Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүд бид ийм ажлуудын төлөө өөрсдийгөө зориулсаар ирсэн. Бид үргэлжид өөрсдийнхөө асуултыг Библи уруу л авчирдаг. Хэдийгээр ингэлээ гээд заримдаа шууд шийдлийг өгөхөөсөө илүүтэй харин ч бүр олон асуултаудыг өгч мэдэх ч бид үүнийгээ больж болохгүй. Бид Библид түшиглэснээр иймэрхүү ярилцлага мөн мэтгэлцээнийг өрнүүлэх үедээ, бид Библийн гол цөмд байгаа зүйл нь юу байдгийг санах хэрэгтэй. Элч нарын тунхаг бол энэ дэлхийн дийлэнх болох Христитгэгчдээр тунхаглагдаж байгаа гэдэг нь итгэгч нарын хоорондын ялгаатай байдлаас үл хамааран чуулганы ам тангарагийн гол цөмд ямар өргөн хүрээний нийтлэг нэгдэл байгааг сануулдаг.



---

# ОНЦГОЙ ДУУДЛАГАДАА ХАРИУЛАХ БИДНИЙ АНДГАЙ

---

## *Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүний дуудлага*

Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүд нь “Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд итгэн зүтгэж, чуулганыхаа үйлчлэлийг хүчирхэгжүүлэхийн төлөө бүх хүчээ зориулахаа” андгайлж байна. Нэгдсэн Методист Чуулганы Магтуу ба Мөргөл (The United Methodist Hymnal) – д байдаг энэхүү андгайн үгийг 2008 оны харгалзагч нарын хурлаас шинэчлэн өөрчилснийг анхааран хараасай гэж хүсч байна. Өмнө нь чуулганы гишүүд бид Нэгдсэн Методист чуулгандаа үнэнч зүтгэхээ амлан андгайлсан. Харин одоо бид урсгалаараа дамжуулан Христэд үнэнч зүтгэхээ андгайлж байна. Энэ үг нь өөрөө маш тодорхой тайлбарыг өгч байгаа учраас, бид энэхүү шинэчлэгдэн тогтсон хэв маягийг ашиглах учиртай. Энэ нь хүчтэй бөгөөд онцгой тунхагаар холбогдон оршдог.

Бидний мэдэж байгаачлан Христитгэгч хүний итгэл нь янз бүрийн чуулганууд болон нөхөрлөлөөр дамжин цогцолдог. Хүн тус бүр Есүс Христээр дамжуулан мэдсэн үнэнээ гэрчилдэг. Мөн тус бүртгээ Ариун Сүнсний хүч дотор Ганц Бурханд үйлчлэхийг эрмэлздэг. Мөн хүн тус бүр элч Паулын өгсөнчлөн дараах сургамжид хэрхэн хариулахаа бодож үздэг: “Иймээс хайрт хүмүүс минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад бүр ч илүү өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр биелүүлэгтүн. Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” (Филиппой 2:12-13). Өөр өөрсдийн урсгал чиглэл болох зөвхөн тэдэнд л байдаг өвөрмөц авьяас чадвар мөн илүү олон чуулган хийгээд дэлхий рүү чиглэсэн дуудлагатай байдаг. Хувь хүмүүсийн дуудлага өөр өөр байдгийн адилаар, чуулгануудын дуудлага ч өөр өөр байдаг. Бурхан хүн тус бүрд ивээлийг өгдөг ч, тэдгээрийн хэн ч байсан төгс биш. Тиймээс чуулганууд харилцан ярилцаж, хамтдаа суралцаж залбирах



нь чухал. Миний хувьд Английн төрийн чуулган<sup>5</sup> болон Пентекост чуулганы найзуудаасаа мөргөлийн талаарх чухал зүйлсийг суралцсан. Мөн Католик чуулганы ахан дүүсээс болон Баптист чуулган, Менонайт чуулган<sup>6</sup>, Лютерын чуулганд хамрагддаг найзуудаасаа баптисмын ёслол болон чуулганд гишүүнээр элсэх ёслолын талаар суралцсан. Өөрийнхөө хамрагддаг Нэгдсэн Методист олон чуулганы хамтрагчдаасаа гадна, өөр урсгалын ухаалаг мэргэн ахлагч багш нараасаа болон өмнөд Баптист чуулганы найз нараасаа сургаал номлолын талаар суралцаж байсан. Энэ бүх харилцан солилцоо нь эрхэм чухал зүйл байсан. Миний хувьд ийм даяар урсгал чуулгануудын харилцан холбоо нь улам багжихыг хүсэн найддаг. Гэхдээ ийм хүсэл байсан ч гэсэн нэг хүн янз бүрийн олон урсгалын чуулганд гишүүн болж чадахгүй. Бид тус бүрдээ өвөрмөц нэг чуулганы итгэгч гишүүнээр дуудагдсан. Бид бол Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүд. Мөн бид энэхүү чуулганаараа дамжуулан Христэд үйлчилдэг. Энэ мэтчилэн бидний өвөрмөц дүр төрх нь бусад урсгал чиглэлийн найзууддаа биднээс дэмжин өгч буй бэлгийн л нэг

---

<sup>5</sup> Шашны шинэчлэл болохоос өмнө Католик шашин Европын нутаг дэвсгэр дээр нэг байсан үед улс бүр өөрийн гэсэн хүчээ бий болгосноор тэргүүн Хамбын үг үр нөлөөгүй болж эхэлсэн. Тэр үед Англи улс Католик шашинг ивээлдээ багтаан улмаар төрийн шашнаа болгосон. Үүнээс 1500 жилийн дараа шашины шинэчлэл бий болж Протестант урсгал, Баптист урсгал үүний дараа Английн төрийн шашин дотроо хуваагдаж Методист урсгал болон Загалмайтны шашин гэх урсгалуудыг гаргасан.

<sup>6</sup> Mennonite чуулган нь шашны шинэчлэл явагдаж байх үед гарч ирсэн Протестант урсгалын нэг бөгөөд Баптист чуулганы хөдөлгөөнд хамрагддаг хэсэг төдий юм.

хэсэг төдий юм.

Бид Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд итгэн зүтгэхээр андгай өгч байгаа нь бидний чуулган л хамгийн сайн чуулган гэх юмуу зөвхөн бид л теологийг өвөрмөцөөр ажиглах чадвартай гэж байгаа хэрэг биш юм. Мөн бидний эргэн тойрны хөршүүд бүгдээрээ Нэгдсэн Методист чуулганы л гишүүд болох ёстой гэсэн үг биш. Хүмүүс бидний нөхөрлөлд ирж оролцвол бид баяртай байдаг. Харин хэн нэг хүн Бурханы дуудлагыг даган ахлагчийн чуулган юмуу Ромын католик чуулган, цэвэр сайнмэдээ чуулганы итгэгч гишүүн болон үйлчлэхээр болбол бид мөн л баяртай байна. Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд итгэн үйлчлэхээр андгай өгнө гэснээрээ бусад чуулгануудын зохистой чанарыг сөргөөр хэлж байгаа хэрэг огт биш юм. Бид зөвхөн, Нэгдсэн Методист чуулган бол Есүс Христэд зүтгэхээр миний дуудагдсан хамгийн сайн газар гэж өөртөө хүлээн зөвшөөрдөг. Энэ утгаараа Бурханаас биднийг нэг чуулган болгохоор өвөрмөц арга замаар бидний амьдралд чиглэсэн онцгой дуудлагыг өгсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм. Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Есүс Христийн дагалдагч болон амьдарна гэдэг нь биднийг нэгдсэн систем (connectional system) – ийн төлөө тослогдон үйлчлэл болон илгээлтийг дэмжин туслана гэсэн утгатай. Бид бол сул холбогдсон орон нутгийн хурлуудын нэгдэл гэж боддоггүй. Эсрэгээрээ янз бүрийн нөхцөл байдалд ч тодорхойгоор илрэн харагдах нэгэн чуулган гэж үздэг. Гэхдээ ингэж холбогдсон нэгдлийн хувьд бидний бүхий л чуулганууд сайн хоолны газрууд шиг адил тэгш нэгэн жигд байх ёстой гэсэн үг биш. Нэгэн жигд биш боловч Бурханы ивээл нигүүлслийг ойлгож чуулганыг хэлбэржүүлэхийн тулд Есүс Христийн дотор ямар нэг нэгдсэн цэг бий гэдэгт итгэдэг. Бид орон нутгийн нийгмийн талбар ба бүх дэлхий рүү чиглэсэн үйлчлэлийн төлөө холбогдсон байдаг. Өөрсдийн андгайг санаарай – бид чуулганыхаа үйлчлэлийг хүчирхэгжүүлэхийн төлөө чуулганаараа дамжуулан Христэд үнэнч зүтгэнэ.

Нэг ижил онд тослогдсон байнгын гишүүн ахлагчийн хувьд Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд үнэнч зүтгэнэ гэдэг нь пасторыг илгээх үйлчлэлийн бие бүрэлдэхүүн дотор ажиллахтай санал нэгтэй байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бишоп болон бусад хүмүүстэй илгээх талаар санал солилцсоны дараа, үйлчлэл явуулах

тохиромжтой орон нутгийнхаа хувьд харьяа урсгалдаа найдна гэсэн утгатай. Мөн Христийн бүхэл биеийн нэг хэсэг болох Нэгдсэн Методист чуулганы нэг гишүүнийхээ хувьд чуулганы түүх ба өвийн тухайд суралцана. Түүнчлэн чуулганы хариуцлага төдийгүй Бурханы энэрэл нигүүлслийн талаарх энэ чуулганы өвөрмөц ойлголтыг ухаарч бодитоор илэрхийлэхийн тулд бүх хүчээ зориулахаар санал нэгдэж байгаа хэрэг юм. Веслийн теологийг болон, түүний дагалдагч бэлтгэх үйлчлэлээс нь суралцана гэсэн үг. Мөн Чарльс Веслигийн зохиосон магтуунуудыг ч сурна. Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүнийхээ хувьд итгэлийн үндсэн зарчим бүхий зориулалтад суралцаж, чуулганыхаа нийгмийн зарчмуудыг хэрэгжүүлэхийн төлөө хичээх болно. Чуулганд хүлээн зөвшөөрөгдсөн эртний ёслолуудыг ашиглаж, Ариун Зоогийн ёслолд байнга оролцож, хэрвээ Ариун Зоогийг удирдах тохиолдолд чуулган нь өөр арга хэлбэрийг ашиглах хүртэл аяганд усан үзмийн дарсыг хийж ашиглана. Чуулганы байр суурьтай бүгд санаа нийлэхгүй байж болох ч, санаа нийлээгүйгээс үүнийг өөрчлөх гэвэл даруугаар хэдийн тогтсон хэлбэрийг ашиглана. Христ болон Түүний сайнмэдээний төлөө Нэгдсэн Методист чуулганы үйлчлэлийг хүчирхэгжүүлж мөн тэрхүү үйлчлэлүүд өргөжин тэлэхийн тулд хийж болох бүхий л хүчээ бүрэн зориулна.

Даяар урсгал чиглэлүүдийн байр сууринаас харвал, бидний өвөрмөц урсгал чиглэлээрээ дамжуулан Христэд үнэнч зүтгэнэ гэх илэрхийлэл нь хэдийгээр бидний тогтоосон хэлбэр ч гэсэн бага зэрэг өвөрмөц санагдах биз ээ. Жишээлбэл, бидний үеэл гэж болох Английн төрийн чуулганы хувьд иймэрхүү илэрхийлэл нь тэдний уламжлалт ёслолд байдаггүй. Бидний Нэгдсэн Методист чуулганы андгайн утга санаа болон нийтлэг чухал шинж нь түүхэн нөхцөл байдлаар тусгагддаг. Энэ нь анхны методистуудын ёслолоос үлдсэн бөгөөд 20 дугаар зуун дахь бидний нийтийн магтууны бүрдэл болон мөргөлийн бүрдэлд гардаг тэрхүү анхны хэлбэр нь дараахтай адил юм. “Та Методист (эсвэл Нэгдсэн Методист) чуулганд үнэнч зүтгэх үү? Мөн залбирал, ирц, авьяас бэлэг, үйлчлэлээрээ дамжуулан чуулганаа дэмжин туслах уу?” Энэ нь Методист чуулганы хагас соёлтой үндсүүд (counter – cultural roots) – ыг тусгаж байгаагийн хувьд, Веслийн хөдөлгөөн нь Английн төрийн чуулганы доторх гишүүдийн цуглаанаар эхэлж байсныг сануулдаг. Веслийн хөдөлгөөн нь даяанчдын цуглааны адилаар гүн зориулалтыг шаардаж байсан хөдөлгөөн учраас, оролцогчид нь

энэхүү хөдөлгөөнөө дэмжиж байсан ч, хөдөлгөөнд оролцоогүй бусад чуулгануудын тухайд шүүмжлэлтэй хандаж байсныг илэрхийлж байв. Хүмүүс төрийн чуулганы найдаж байснаас илүүгээр зориулалт гаргахаар шийдэж хөдөлгөөнд нэгдэж байв. Веслигийн үед үргэлжлэн цуглах хийгээд ерөнхий дүрэмд дасгалжуулагдаж байлаа. Түүхэн ийм үндэслэлд үнэнч зүтгэх үед, Методист чуулган маш өндөр түвшиний зориулалт бүхий хөдөлгөөн болсон байна. Энэхүү андгай нь үүнтэй адилаар зориулалтын тухайд өндөр хүсэл найдварыг бодогдуулж чадах юм. Хэрвээ Нэгдсэн Методист чуулган Английн Төрийн чуулган эсвэл бүр цаашлаад Ромын Католик чуулгантай нэгэн урсгал чиглэл болох юм бол, хагас соёлын тогтолцооны төлөөлөгчийн хувьд Нэгдсэн Методист Чуулганы утга санаа нь өөр бусад чуулганд өгч чадах хамгийн чухал бэлгүүдийн нэг болох юм.

Зарим хүмүүс Нэгдсэн Методист чуулганаар дамжуулан Христэд үнэнч зүтгэхээр андгай өргөх нь амьдралынхаа турш Нэгдсэн Методист чуулганы гишүүн байхаар амлаж буй хэрэг эсэхийг гайхшран бодох нь бий. Заавал тийм байх албагүй. Харин өөрөө урьдчилан мэдэж болох ирээдүйдээ Нэгдсэн Методист чуулганы гишүүнийхээ хувьд амьдралаа зориулна гэсэн утгатай. Мэдээж Бурхан л биднийг удирдан захирдаг Нэгэн гэдэгт бид итгэдэг. Ийнхүү Бурханы хаанчлалын талаар бодохдоо, бид 5 жил, 10 жил, 20 жилийн дараа өөрсдийгөө юу хийж явахыг огтхон ч хэлж мэдэхгүй. Зөвхөн Бурхан л мэднэ. Ирээдүйд би, Бурхан намайг өөр урсгал чиглэлээр дамжуулан Өөрт нь үйлчлүүлэхээр дуудсан гэж ч хэлж болох юм. Миний итгэгч гишүүний андгай нь ийм боломжийг хязгаарлахгүй. Уур хүрч, цөхрөх үед энэхүү андгай нь түргэн зангийн минь шийдвэрийг хязгаарлаж өгөөсэй гэж хүснэ. Харин хэрэв гүн гүнзгий бодож үзээд Нэгдсэн Методист чуулган нь цаашид Бурханы дуудлагад хариулахын төлөөх хамгийн сайн газар биш гэж бодогдвол, би амар тайван замаар итгэгч гишүүний андгайнаасаа буцах болно. Итгэгч гишүүнийхээ андгайнаас буцсан ч, би Нэгдсэн Методист чуулгандаа хохирол учруулалгүй, Бурхан энэ чуулганаар дамжуулан ажиллаж байгааг хүлээн зөвшөөрч Нэгдсэн Методист чуулганы үйлчлэлийг дэмжих болно.

## ***Бие даасан чуулганы итгэгч гишүүний хувьд Христэд үйлчлэх дуудлага***

Нэгдсэн Методист чуулганы итгэгчид нь “Залбирал, ирц, авъяас чадвар, үйлчлэл болон гэрчлэлээрээ дамжуулан чуулганыхаа үйл ажиллагаанд чин сэтгэлээсээ оролцоно” гэдгээ амладаг. Баптисмын ёслол дээр энэхүү андгайг өргөснөөр бие даасан чуулганы итгэгч гишүүнээр хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд, энэ хэсэг нь хуран цугласан хүмүүсийн тухай тайлбарлан авч үзэх болно. Энэхүү андгай нь шинэчлэгдсэн (“гэрчлэл” багтсан) хамгийн сүүлийн үеийн андгайн зааврыг ашиглах хэрэгтэй. Энэхүү андгай нь нэг алхамын цаадах өвөрмөц зүй тогтлыг агуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, Христигтэгч хувь хүний зориулалт нь онцгой нэг орон нутаг дахь хамт олны дотор илүү хөгжиж илэрхийлэгдэх ёстой гэж үздэг. Христигтэгч нь онцгой харилцаа, асуудал болон сорилтоор дүүрэн ээдрээтэй нөхцөл дотроос Бурханы ивээлтэй – “төгс байдал уруу чиглэсэн” – ариусал уруу урагшилдаг. Дээр өгүүлсэнчлэн Веслигийн “Дэлхий бол миний номлолын индэр” хэмээх үг нь түүний авралын зарын төлөөх зүтгэлийг нь тайлбарлах үүднээс дурьдагдсан байдаг. Гэхдээ энэ нь бие даасан чуулганы амьдралд байраа олсон харилцааны хүч ба хариуцлагуудыг үгүйсгэж буй хэрэг огтхон ч биш ээ.

Христчин хүний амьдралд онцгой хирнээ тодорхой зориулалт дагалдаж байдаг. Христчин хүнийхээ хувьд бид Бурханыг болон хөршөө хайрлахаар дуудагдсан. Бурхан биднийг “Зөвийг үйлд, энэрлийг хайрла,....” (Мика 6:8) – хэмээн дуудсан гэдэгт итгэж байна. Бид Мартин Льютер Кинг пасторын арьс өнгөний эрх тэгш байдлын тухай мөрөөдөлд сэтгэл догдолж болох юм. Мөн бид бусдыг ойлгодог, найрсаг чуулган хэрэгцээтэй байгаа талаар халуунаар ярьж болох юм. Тодорхой орон нутагт ажиллаж амьдарч байгаа Христигтэгчийнхээ хувьд бид иймэрхүү зүтгэл зориулалтыг онцгой бөгөөд тодорхой арга замаар гэрчилж чадна. Тэргэнцэртэй эмэгтэй чуулганд ирдэг боллоо гээд төсөөлөөд үзэцгээе. Хэдийгээр тэр чуулганд хүрэлцэн ирсэн ч, шууд асуудалтай тулгарна. Та түүнийг баяртайгаар угтан авахдаа итгэлтэй байгаа ч, танай чуулганы байшинд зориулалтын зам байхгүй бол тэргэнцэртэй шагаар өгсөж чадахгүй, ариун цэврийн ерөөнд ч тэргэнцэртэй орох зай байхгүй. Эмэгтэйн хүрэлцэн ирсэн

нь чуулганыг ичгүүрт оруулаад зогсохгүй эмгэнэлтэй болгож орхино. Ийм нөхцөл байдалд өнгөрсөн амралтаараа зочилж очихдоо хальт харахад найрсаг бус харагдах чуулганы талаар хэлж байсан үгээ дахин гаргаж чадахгүй болох болно. Яагаад гэвэл, одоо та өөрөө баяртайгаар угтан авахад саад болж буй асуудал чуулганд тань байгааг ойлгоно.

Та юу хийх вэ? Гишүүдийг зарлан хуралдахыг хүсээд энэ асуудлаар санал солилцож эхэлнэ. Тэгээд тэргэнцэртэй зорчиж болохоор чуулганыхаа барилгыг засварлахын тулд их хэмжээний мөнгө, цаг хугацаа хэрэгтэй болохыг мэднэ. Хурлын төлөөлөгч ингэж хэлнэ: “Чуулган маань ялгаварлалгүйгээр бүх хүмүүсийг ойлгодог чуулган болохыг хүсч байна. Магадгүй төв оффиссоос бидэнд мөнгөн тусламж үзүүлэх байх.” Үнэхээр мөнгөн тусламж авч чадах эсэхийг мэдэхээр хэн нэгнийг томилно. Дараагийн хурал дээр нөгөө хүн маань тайлагнахдаа мөнгөн тусламж авч чадсан ч, тэр мөнгө нь маш бага учраас цахилгаан шат суурилуулах нь байтугай налуу зам ч барьж хүрэлцэхгүй гэдгийг хэлнэ. Сорилт амархан биш ээ. Энэ хооронд тэргэнцэртэй эмэгтэй байнга л барилгыг сайжруулахыг шаардахын хамт бага багаар улам бүр чуулганы нэг хэсэг болж байгаа.

Чуулганд ирэхийг хүсэвч чуулганд өөрийн дураар алхаж чадахгүйгээсээ болж ирж чадахгүй байгаа хүмүүс байдгийг та мэдэх болно. Тэр хүмүүс гагцхүү чуулганы тань барилгын иймэрхүү асуудлын талаар дээрх эмэгтэй шиг шаргуу шаардахгүй л байгаа болохоос.

Эцэст нь та бүгдийг төлөөлөн үнэнч найдвартайгаар ажиллаад өгчих хүн байхгүй болохыг та болон танай чуулганы гишүүд ойлгох болно. Энэ ажил нь таны өмнө тавигдсан бөгөөд, та бүгдийг л энэ ажлыг шийдвэрлээсэй гэж Бурхан хүсэж байгаа. Ихэнхдээ барилгын засварын ажилд шаардагдах гол хөрөнгө нь энэхүү төслийг дэмжиж буй гишүүдээс гардаг. Олон чуулганы хувьд саяын дурдсан ийм төрлийн байдал болон нэг яаралтай шийдвэрлэх хэрэгтэй нөхцөл байдалтай нүүр тулсан байдаг. Олон чуулган Бурханы ивээлээр товлосон хугацаандаа зөв ажлуудыг зохион явуулдаг. Тэд хөршийнхөө хүүхдүүдийн төлөө цэцэрлэгийн хүүхдийн хөтөлбөрүүд болон өөр олон үйлчлэлүүдийг явуулдаг. Мөн залуус, насанд хүрэгчдэд зориулсан Библийн сургалтуудыг шинээр нээж, гэр бүл салсан хүмүүс,

тэжээгчээ алдсан хүмүүсийн төлөө дэмжих бүлгүүдийг байгуулж, чуулганд явдаггүй хүмүүсийн хэрэгцээнд онцгойлон анхаарч мөргөлийн шинэ хэлбэрүүдийг хөгжүүлсэн. Ариун Сүнс янз бүрийн арга замаар хурсан олны сэтгэлийг хөдөлгөж бүх хүчээ дайчлахад тусалсан. Үүнд олон итгэгчид чин үнэнчээр хариу үзүүлж Бурханы ивээсэн энэрэл нигүүлсэл, зөв шударгын гэрч болцгоодог. Нарийн тодорхой арга замаар дамжуулан орон нутгийн чуулганыг дэмжинэ гэсэн энэхүү андгай нь бидний авралын зарын талбар бол бидний хөршөөс эхэлдэг юм гэдгийг сануулдаг.

Мэдээж бидний хүсэл сонирхол үүгээр огтхон ч зогсохгүй. Анхны үеийн методист чуулганы аялан номлодог номлогчдын гэрчлэлүүд энэ мэтийн тулга тойрсон анхаарал сонирхлыг буруушаан зэмлэдэг байсан. Бидний хөршүүдэд тулгарсан хэрэгцээнүүдийн улмаас, Африкт дэлгэрсэн ДОХ, нян тараагч шумуулаас хамгаалах халхавч хэрэгтэй байгаа хүмүүс, Дундад Азиас дүрвэгсдийн шаналал уй гашуу, эрүүл мэндийн зохих үйлчилгээг авч чадахгүй байгаа хүмүүс, мөн одоо ч гэсэн хараахан авралын Сайн мэдээг сонсоогүй байгаа хүмүүсийн хэрэгцээнээс нүүр буруулж болно гэсэн зөвшөөрлийн бичгийг авсан юм биш. Харин та хийе гэж хүсэх л юм бол, иймэрхүү хэрэгцээнүүдийг орон нутгийнхаа нөөц бололцооныхоо харилцааны шугамаар дамжуулан сайнаар шийдвэрлэж чадна. Мөнгө, эд зүйлийг хүлээн аваад дамжуулж өгч болно, хууль дүрэм тогтоол шийдвэр нь нэвтрэлцэж болох ч, эцсийн эцэст хэн нэгэн хүн тухайн орон нутагт очиж тэдний дотор чуулган тарьж Бурханд тэдний залбирал, ирц оролцоо, авъяас чадвар, үйлчлэл болон гэрчлэлийг өргөн мөргөх учиртай. Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүний андгай нь энэ ертөнцийг өөрсдийнхөө итгэлийн ертөнц өөрсдийнхөө хөрш болгохыг хүсэн шаарддаг юм.



---

## ХАВСРАЛТ

---

Accountable Discipleship, Living in God’s Household, by Steven W. Manskar (Discipleship Resources, 2000)

Baptism, Christ’s Act in the Church, by Laurence Hull Stookey (Abingdon Press, 1982)

“By Water and Spirit, A United Methodist Understanding of Baptism,” The Book of Resolutions of The United Methodist Church, 2012 (The United Methodist Publishing House, 2012) 922-42

Come to the Waters, Baptism and Our Ministry of Welcoming Seekers and Making Disciples, by Daniel T. Benedict, Jr. (Nashville: Discipleship Resources, 1996)

Sacraments and Discipleship, Understanding Baptism and the Lord’s Supper in a United Methodist Context, by Mark W. Stamm (OSL Publications, 2013; originally published by Discipleship Resources in 2001)

The Cost of Discipleship, by Dietrich Bonhoeffer (New York: Collier Books, 1959)

The Early Methodist Class Meeting, by David Lowes Watson (Nashville: Discipleship Resources, 1992).

---

## ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

---

Марк В Стэм (Mark W. Stamm) нь Бостоны Их сургуульд (Boston University) теологоор докторын зэрэг хамгаалсан, одоо Southern Methodist University Методист их сургуулийн Покинс магистрын ангид (Perkins School of Theology) Христитгэлт мөргөл судлалаар багшилж байна. Стэм доктор нь хойд Тэхас (North Texas) мужийн хэсэгт харьяалагддаг ба Нэгдсэн Методист чуулганы пастор юм.